



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2003 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

Г

Г

Улсын нисэхийн тухай Монгол улсын хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэчлэн боловсруулсан "Нисдэг тэрэгний нислэгийн зохицуулалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг 2003 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Иргэний агаарын тээврийн удирдах газрын даргын 1998 оны 186 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.



М.ДАГВА

ИНЕГ-ын Даргын 2003 оны
тоот тушаалын хавсралт

НИСДЭГ ТЭРЭГНИЙ НИСЛЭГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Нисдэг тэргээр зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх, тусгай, онцгой үүргийн болон аж ахуйд үйлчлэх нислэгийг гүйцэтгэхэд энэ журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэ журмыг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Иргэний нисэхийн багц дүрмийн заалтууд, тухайн нисдэг тэргэний нислэгийн ашиглалтын заавар болон бусад холбогдох бичиг баримтын зохих заалтуудад нийцүүлэн хэрэглэнэ.

Хоёр. Нислэгийн ангилал

2.1 Нисдэг тэргээр гүйцэтгэх нислэгийг дараах байдлаар ангилна:

2.1.1 *Онцгой үүргийн нислэг*- гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын дээд болон өндөр хэмжээний зочин төлөөлөгчийг тээвэрлэх нислэгийг,

2.1.2. *Тусгай үүргийн нислэг*- гэж хүний амь аврах, байгалийн гамшиг тохиолдсон үед туслах, эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах зорилгоор үйлдэх нислэгийг,

2.1.3. *Аж ахуйд үйлчлэх нислэг*- гэж дүүжин тээвэрлэлт, геологи хайгуулын ажил хийх, агаараас зураг авах, шүхэрчид буулгах түймрийн эргүүлийн нислэг, тогтмол бус чиглэлээр бүлэг хүмүүс тээвэрлэхэд зориулан хангалт, үйлчилгээний нэмэгдэл арга хэмжээ авч урьдчилан бэлтгэгдсэн нислэгийг,

2.1.4. *Зорчигч тээврийн нислэг* - гэж тээвэрлэгч байгууллагатай гэрээ хийж тийз авсан зорчигчийг тээвэрлэх нислэгийг.

Гурав. Нислэг үйлдэх

3.1. Онцгой үүргийн нислэгийн зохицуулалтыг Төрийн тусгай хамгаалалтын газар /ТТХГ/, Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын дарга нарын хамтарсан тушаалаар батлагдсан "Онцгой үүргийн нислэгийн журам"-ын дагуу гүйцэтгэнэ.

3.2. Цаг агаарын байдал, техникийн татгалзал, буух хөөрөх талбайд саад тохиолдсон зэрэг нөхцөлд агаарын хөлгийн дарга аюулгүй ажиллагаанд харшлахгүйгээр буух хөөрөх өөр талбайг сонгож болно.

3.3. Онцгой үүргийн нислэг үйлдэх нисэх багийг агаарын хөлгийн дарга, багш нисэгч нараар бүрдүүлэх бөгөөд нисэх багийн даргыг агаарын хөлгийн даргын суудлаас, багш нисэгчийг баруун талын суудлаас нисгэж, эрх үүргийг Нислэгийн ашиглалтын зааварт тодорхойлсны дагуу гүйцэтгүүлнэ.

3.4. Зорчигч тээврийн тогтмол нислэгийн үед нисдэг тэрэг зөвхөн батлагдсан аэродром, вертодром, тусгайлан бэлтгэгдсэн талбайд буулт, хөөрөлт үйлдэнэ.

3.5. Талбай сонгож буух үед буулт хөөрөлтийн талбайн хэмжээ, түүний орчмын дэвсгэр газар нь тухайн нисдэг тэрэгний Нислэгийн ашиглалтын зааварт заагдсан стандарт шаардлагыг хангасан байх ёстой.

3.6. Нисэх баг агаараас талбай сонгож буусан тохиолдол бүрт буусан цэгийн координат (уртраг, өргөргийн огтолзол)-ыг нислэгийн удирдагчид 1 градусын нарийвчлалтай илтгэх ба уг талбайгаас хөөрөх урьдчилсан хугацааг 30 минутын нарийвчлалтай товлон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад мэдэгдэнэ.

3.7. Агаарын хөлгийн дарга талбай сонгож буухын өмнө, буух талбай дээгүүрээ туршилтын оролтыг заавал хийсэн байх ёстой.

3.8. Талбай сонгож буух үеийн нислэгийн жинг, тухайн талбайд агаарын дэр хэрэглэн дүүжин нислэгээр тогтож чадахуйц байхаар урьдчилан тооцоолсон байна.

3.9. Агаарын хөлгийн дарга нислэгийн үед байнгын холбоотой явах бөгөөд буусан тухайгаа мэдэгдэх боломжгүй тохиолдолд буулт үйлдсэнээс хойш 30 минутын дотор холбооны бусад хэрэгсэл ашиглан нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад энэ тухай мэдэгдэнэ.

Дөрөв. Тээвэрлэлт хийх

4.1. Нисдэг тэргээр зорчигч, тээш, ачаа, шуудан тээвэрлэхдээ "Зорчигч, тээш, ачаа, шуудан тээвэрлэх дүрэм", тухайн нисдэг тэрэгний Нислэгийн ашиглалтын зааврыг баримтална.

4.2. Нислэгийн бүхий л хугацаанд нисдэг тэрэг дотор тамхи татах, гал гаргахыг хатуу хориглоно.

4.3. Нисдэг тэргээр аж ахуйд үйлчлэх болон тусгай үүргийн нислэг үйлдэхдээ нислэгийн алслалтыг нэмэгдүүлэх зорилгоор нэмэгдэл түлшний савыг байрлуулж болно.

4.4. Хойд хаалга (створка) авсан үед зөвхөн шүхрээ өмссөн шүхэрчдийг зорчигчдын бүхээгт суулгаж болох бөгөөд тусгайлан зөвшөөрснөөс бусад бүх тохиолдолд хойд хаалга нээлттэй нисэхийг хориглоно.

4.5 Нисдэг тэргээр аюултай ачаа (тэсэрч дэлбэрэх бодис, хий, шингэн, шатагч болон хортой, цацраг идэвхит бодис зэрэг) тээвэрлэхдээ ИНД-92-р дүрэм /Аюултай ачаа тээвэрлэх/-ийн заалтуудыг баримтална.

4.6 Нисдэг тэргээр хүн ам нягт суурьшсан хот, суурин газрын дээгүүр нислэг үйлдэхдээ Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 25-р зүйлийг баримтлах бөгөөд тухайн суурин газрын нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг албан ёсоор авсан байна.

4.7. Нисдэг тэрэгнээс ан хийх нислэгийг ИНЕГ болон холбогдох бусад газруудаас зөвшөөрөл авсны үндсэн дээр үйлдэнэ.

4.8. Ан хийх нислэгийн үед тухайн нисдэг тэрэгний Нислэгийн ашиглалтын зааврыг удирдлага болгоно. Энэ нислэгийн ажиллагаанд оролцох бүх этгээдэд агаарын хөлгийн дарга аюулгүй ажиллагааны зааврыг танилцуулж гарын үсэг зуруулсан байна.

Тав. Нислэгийн захиалга

5.1. Тусгай үүргийн (хүний амь аврах, байгалийн гамшиг тохиолдсон үед туслах, эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх, эрэн хайх авран туслах болон бусад) яаралтай нислэгийн захиалгыг нислэг эхлэхээс 2 цагийн өмнө, аж ахуйд үйлчлэх нислэгийн захиалгыг нисдэг тэрэгний нислэгийн онцлогийг харгалзан, тухайн агаарын зам, аэродром, талбайг тогтмол ашигладаг эсэхээс үл хамааран нислэг эхлэхээс 24 цагийн өмнө нислэгийн үйлчилгээний байгууллагад өгсөн байна. Тусгай үүргийн нислэгт хамаарахгүй боловч зайлшгүй шаардлага (ИНЕГ-аас зөвшөөрөл авсан, тухайн нислэг зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон, нислэгийн үйл ажиллагаа иргэний нисэхийн холбогдох хууль, дүрэм, журамд харшлахгүй)-ын улмаас нислэг үйлдэх тохиолдолд нислэгийн захиалгыг нислэг эхлэхээс 4 цагийн өмнө өгч болох бөгөөд энэ нислэгийн зөвшөөрлийн эцсийн шийдвэрийг нислэгийн хангалтууд болон цаг агаарын байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага гаргана.

5.2. Тогтмол ашигладаггүй агаарын зам, аэродромуудаар онцгой үүргийн болон зорчигч тээврийн нислэг үйлдэх, мөн нисдэг тэргэнд тусгай тоног төхөөрөмж суурилуулах, дүүжин тээвэрлэлтийн нислэгийн захиалгыг 3 хоногийн өмнө Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад өгч зөвшөөрөл авсан байна.

5.3. Нисдэг тэрэгний нислэгийн аливаа захиалгад буулт хөөрөлт үйлдэх газрын нэрнээс гадна уг газрын координат (уртраг, өргөргийн огтлолцол)-ыг заавал оруулж өгнө.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Энэ журам нь батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

-----X-----